



**Харилцаа холбооны зохицуулах хорооны  
2022 оны ээлжит 07 дугаар хуралдааны  
мэдээлэл**

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2022 оны ээлжит 07 дугаар хуралдааныг 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдөр холимог оролцоотой (биеэр болон цахим) хэлбэрээр зохион байгуулсан.

Тус хуралдаанаар "Хөдөлгөөнт холбооны 5G сүлжээний радио давтамжийн хуваарилалт ба зохицуулалт"-ын баримт бичгийн төслийн тухай (Хорооны 2022 оны 07 дугаар хуралдааны Тэмдэглэл, ээлжит 6 дугаар хуралдаанаас өгсөн чиглэл, үүрэг даалгаврын тухай); ХХЗХ-ны төлөөлөгчид Сингапур, Малайз улсад албан томилолтоор ажилласан тайлан, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний саналын тухай танилцуулга; ХХЗХ-нд 2022 оны эхний хагас жилд ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар танилцуулга; Тусгай зөвшөөрлийн тухай (Тусгай зөвшөөрөл шинээр олгох, сэргээх, зөвшөөрөл шилжүүлэх, нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох тухай); Бусад: Тогтоолын холбогдох хэсгийн хүчингүй болгох тухай /ТЗ цуцлах тухай/ зэрэг нийт 5 асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн болно.

Тус хуралдаанд Зохицуулах хорооны 2022 оны 07 дугаар хуралдааны тэмдэглэл, 2022 оны ээлжит 06 дугаар хуралдаанаас "Хөдөлгөөнт холбооны 5G сүлжээний радио давтамжийн хуваарилалт ба зохицуулалт"-ын баримт бичгийн төслийн талаар өгсөн үүрэг, удирдамж чиглэлийг тусгасан байдал, хэрэглэгчийн тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл, түүний цаашдын чиг хандлага, туршлага, үйлчилгээ эрхлэгч нар, эрх ашиг нь хөндөгдөж байгаа хуулийн этгээд нараас гарсан саналыг уулзалтын протокол, саналыг албан тоотоор албажуулж авч баримт бичигт эцэслэн тусгасан байдал, үүрэг даалгаврын хэрэгжилтийн явцын талаар танилцуулгыг хэлэлцүүлэв. Энэхүү асуудлаар РДХЗГ-аас эрх ашиг нь хөндөгдөж байгаа ААН, хуулийн этгээдийн удирдлагын түвшинд баримт бичгийн зарчмын зөрүүтэй санал, заалтын талаар уулзалт зохион байгуулж, нэгдсэн ойлголцол шийдэлд хүрэх, баримт бичгийн төслийг эцэслэн 2022 оны 4 дүгээр улиралд багтаан Хорооны хуралдаанд хэлэлцүүлэхийг холбогдох газар, хэлтэст даалгав.

ХХЗХ-ны 2022 оны ээлжит 07 дугаар хуралдаанд Харилцаа холбооны зохицуулах хорооны төлөөлөгчид Сингапур, Малайз улсад албан 2022 оны 6 сард томилолтоор ажилласан тайлан, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний саналын тухай танилцуулгыг сонсов. Тус хуралдаанаас Сингапур, Малайз улсын зохицуулах байгууллагын хэрэгжүүлж байгаа цахим орчин, өргөн нэвтрүүлэг, контентын зохицуулалтын тэргүүн туршлагыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх ажлын төлөвлөгөө гарган ажиллах, зохицуулалтын шинэ хандлагууд, орчны өөрчлөлтийг Монгол улсын зохицуулалтын баримт бичиг, техникийн нөхцөл шаардлага, радио давтамжийн хуваарилалтад харгалзан үзэх, нийцүүлэн боловсруулах чиглэлээр ажиллахыг холбогдох газар, хэлтсийн удирдлагад даалгав.

Зохицуулах хороо нь "Харилцаа холбооны зохицуулах хороонд ирүүлсэн санал, гомдлыг хүлээн авах, хянах, шийдвэрлэх журам" болон "Иргэдээс төрийн

байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль”-д зааснаар 30 хоногийн дотор хянан шийдвэрлэж, холбогдох хариу хүргүүлж байна. Байгууллагын хэмжээнд иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудаас гаргасан санал, гомдол, хүсэлтийг дараах хэлбэрүүдээр хүлээн авч байна. Үүнд: албан бичиг, өргөдлөөр; Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах төв /11-11 төв/; утас /1800-1858, 304258/; и-мэйлээр [/info@crc.gov.mn/](mailto:info@crc.gov.mn); биечлэн; цахимаар зэрэг болно. Тус хороонд 2022 оны эхний хагас жилд нийтдээ 370 гаруй санал, гомдол дээр дурдсан хэлбэрээр ирүүлснийг холбогдох хууль, журамд заасан хяналтын хугацаанд шийдвэрлэж ажилласан талаар сонсов. Хуралдаанаас хэлэлцүүлсэн асуудлаар хариуцсан газар, хэлтэст 2022 оны эцсийн байдлаар нэгтгэн хорооны хуралдаанд хэлэлцүүлэх, цаашид байнга тогтмол гарч буй гомдолд хариу өгөх хууль, тогтоомжийн үндэслэл бүхий загварыг бий болгох; гомдол бүртгэх дэлгэрэнгүй тодорхойлолт бүхий ангилал үүсгэх – анализ хийхэд хялбар болгох; өргөдөл, санал гомдол хүлээн авах систем хөгжүүлэх нь зүйтэй гэж үзэв.

Хорооны 2022 оны ээлжит 07 дугаар хуралдаанаар “Тусгай зөвшөөрөл олгох тухай”, “Тусгай зөвшөөрөл сэргээх тухай”, “Тусгай зөвшөөрөлд нэмэлт өөрчлөлт оруулах тухай”, “Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай” холбогдох газар, хэлтсийн боловсруулсан танилцуулга, үнэлгээний дүгнэлт бүхий 4 тогтоолын төслийг хавсралтын хамт тус тус хэлэлцээд, тус хуралдаанаас 4 тогтоолыг хавсралтын хамт батлан шийдвэрлэсэн. Үүнд:

- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, 12 дугаар зүйл, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 34 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5 дах хэсгийг тус тус үндэслэн 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 32 тоот тогтоолын хавсралтаар 9 хуулийн этгээдэд 10 тусгай зөвшөөрлийг шинээр олгосон;
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4 дэх заалт, 13 дугаар зүйлийн 13.3 дах хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 34 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 6 дугаар зүйлийн 6.6 дах хэсгийг тус тус үндэслэн 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 33 тоот тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг сэргээсэн;
- Харилцаа холбооны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.15 дах заалт, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 34 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 5.1.1 дэх заалт болон 5.3 дах хэсгийг тус тус үндэслэн 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 34 тоот тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулсан;
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5 дах заалт, 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 34 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 35 тоот тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгон тус тус шийдвэрлэв.

Харилцаа холбооны зохицуулах хорооны холбогдох газар нэгжийн зарим тусгай зөвшөөрлийг цуцлах саналын тухай танилцуулга, санал дүгнэлт, тогтоолын төслийг

тус тус 2022 оны ээлжит 07 дугаар хуралдаанаар авч хэлэлцээд, Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалтыг тус тус үндэслэн 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн “Тогтоолын холбогдох хэсгийг цуцлах тухай” 36 тоот тогтоолыг хавсралтын хамт батлав. Энэхүү баталсан тогтоол, хавсралтаар тусгай зөвшөөрөл олгохоор шийдвэр гарсан боловч тусгай зөвшөөрлийн гэрээ байгуулаагүй, гэрчилгээ аваагүй тогтоолын хавсралтад заасан нэр бүхий 3 хуулийн этгээдэд 4 тусгай зөвшөөрөл олгох тухай тогтоолын тухайн хуулийн этгээдэд холбогдох хэсгийг цуцалж, олгосон тусгай зөвшөөрлийн тус тус хүчингүй болгов.

(Хуралдааны баталсан тогтоолын жагсаалт, холбогдох хавсралтыг <http://www.crc.gov.mn/main.php?cid=1&do=70&did=0> үзнэ үү).

Харилцаа холбооны зохицуулах хороо  
2022-07-29